

**Ашгийн бус тодорхой заагдсан үйл ажиллагаат хуулийн этгээд  
“Монголчуудын Холбоо-Япон”**

## **Д Ү Р Э М**

**Нэгдүгээр бүлэг: Ерөнхий зүйл**

**(Нэршил)**

Зүйл 1. Энэхүү хуулийн этгээдийг Ашгийн бус тодорхой заагдсан үйл ажиллагаат “Монголчуудын Холбоо-Япон” (цаашид “Холбоо” гэх) гэж нэрлэнэ.

2. Холбооны нэр англи хэлээр “Mongolian Association in Japan”, япон хэлээр “モンゴル人協会・日本” байна. “モンゴル人協会・日本” нь байгууллагын албан ёсны бүртгэлтэй нэр байна.

**(Хаяг)**

Зүйл 2. Холбооны үндсэн байршил нь доорх болно.

**231-0001 Kanagawa ken, Yokohama shi, Naka-ku,  
Shinminato 2-2-1 Yokohama World Porters 6F**

**(Зорилго)**

Зүйл 3. Тус Холбоо нь Япон улсад ажиллаж амьдарч буй Монголчуудын нэгдмэл байдлыг дэмжиж, нийгмийн харилцааны баялгийг бүрдүүлэн, Монгол-Япон хоёр орны олон талт хамтын ажиллагаа болон нийгмийн хөгжилд бодит хувь нэмэр оруулах зорилготой.

**(Ашгийн бус тодорхой заагдсан үйл ажиллагааны чиглэл)**

Зүйл 4. Холбоо нь дээрх зорилгыг хэрэгжүүлэхийн тулд Ашгийн бус тодорхой заагдсан үйл ажиллагааг хөхүүлэх хуульд (цаашид “АБТЗҮАХ хууль” гэх) заагдсан дараах чиглэлийн үйл ажиллагааг явуулна:

- Эрүүл мэнд, нийгмийн сайн сайхан байдлыг дээшлүүлэх
- Эрдэм боловсрол, соёл зан заншил, урлаг спортыг дэлгэрүүлэх
- Олон улсын хамтын ажиллагааг дэмжих
- Эдийн засгийн хөгжлийг дэмжих

-АБТЗҮАХ хуулиар тогтоосон үйл ажиллагааг явуулагч бусад байгууллага, тэдний үйл ажиллагааг холбох, зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх төрөл бүрийн үйл ажиллагаа

**(Үйл ажиллагааны төрөл )**

Зүйл 5. Холбоо нь 3-р зүйлд тусгасан зорилгыг хэрэгжүүлэхийн тулд ашгийн бус тодорхой заагдсан үйл ажиллагаатай холбогдох доорх төрлийн үйл ажиллагааг явуулна.

- (1) Нийгмийн судалгаа, статистик мэдээлэл боловсруулалт, дүн шинжилгээ
- (2) Эрүүл мэндийн салбарт төсөл хэрэгжүүлэх, нийгмийн халамж, эрүүл мэндийн салбарт хоёр орны хамтын ажиллагааг дэмжин ажиллах
- (3) Соёл урлаг спортын арга хэмжээ, боловсрол, бизнесийн семинар, үзэсгэлэн худалдаа зохион байгуулах
- (4) Монгол Японы эдийн засгийн хамтын ажиллагаа, бизнес түншлэлийг өргөжүүлэн дэмжих үйл ажиллагаа, хөтөлбөр хэрэгжүүлэлт
- (5) Мэдээлэл холбоо, цахим технологийг ашигласан мэдээлэл хангамж, ахуйн зөвлөгөө, мэдээлэл солилцооны дэмжлэг
- (6) Ном товхимол, биет эсвэл онлайн сонин хэвлэл
- (7) Боловсролыг дэмжих, хүний нөөцийг бүрдүүлэхтэй холбоотой үйл ажиллагаа
- (8) Холбооны зорилгыг хэрэгжүүлэхэд шаардлагатай бусад үйл ажиллагаа

2. Холбоо нь дор дурдсан “бусад” төрлийн үйл ажиллагааг явуулна.

- (1) Гишүүд болон гишүүн бус иргэд байгууллагад зориулсан туслалцааны төлбөртэй үйлчилгээ

3. Дээрх үйл ажиллагаанууд нь 1 дүгээр хэсэгт заасан үйл ажиллагаанууддаа харшлахгүй байх ба эндээс бий болох ашиг орлого нь 1 дүгээр хэсэгт заасан үйл ажиллагаанууддаа зориулагдахаар байна.

**Хоёрдугаар бүлэг: Гишүүнчлэл**

**(Ангилал)**

Зүйл 6. Холбооны гишүүн нь дараах ангилалтай байх ба үндсэн гишүүнийг АБТЗҮАХ хуульд заасан “бүрэлдүүлэгч гишүүн” (shyain) гэж үзнэ.

1. Үндсэн гишүүн: Холбооны зорилгыг хүлээн зөвшөөрч элссэн, холбооны

удирдлага, үйл ажиллагаанд идэвхтэй оролцохоо илэрхийлсэн хувь хүн буюу байгууллага.

2. Энгийн гишүүн: Холбооны зорилгыг хүлээн зөвшөөрч элссэн хувь хүн буюу байгууллага.

#### **(Гишүүн элсүүлэлт)**

Зүйл 7. Гишүүн элсүүлэхэд тусгай нөхцөл шаардахгүй болно.

2. Гишүүнээр элсэх хүсэлтэй хүн Тэргүүний батламжилсан маягыг бөглөж Тэргүүнд хандсан өргөдөл гаргана.
3. Тэргүүн нь дээрх өргөдлийг хүлээн авч, татгалзах зүй ёсны шалтгаангүй тохиолдолд элсэн орохыг хүлээн зөвшөөрнө.
4. Тэргүүн нь энэ зүйлийн 2 дахь хэсгийн дагуу хүсэлт гаргагчид татгалзсан хариу өгөх тохиолдолд уг шалтгааныг бичгээр, зохих хугацааны дотор мэдэгдэнэ.

#### **(Гишүүний бүртгэлийн хураамж болон татвар)**

Зүйл 8. Гишүүн нь Нэгдсэн хурлаар тусгайлан тогтоосон бүртгэлийн хураамж болон татвар төлнө.

#### **(Гишүүний эрхийг цуцлах)**

Зүйл 9. Доорх тохиолдолд гишүүний эрхийг цуцалж болно.

- (1) Өөрөө гарах хүсэлтээ илэрхийлсэн
- (2) Уг хүн нас барсан эсвэл тухайн байгууллага татан буугдсан
- (3) Хоёр сараас илүү хугацаагаар татвараа төлөөгүй
- (4) Хасагдсан

#### **(Гишүүнчлэлээс чөлөөлөгдөх )**

Зүйл 10. Гишүүн нь Тэргүүнээс баталсан маягтын дагуу гишүүнчлэлээс чөлөөлөгдөх хүсэлтээ Тэргүүнд гаргана.

#### **(Гишүүнчлэлээс хасах)**

Зүйл 11. Доорх тохиолдлуудад Нэгдсэн хурлын шийдвэрийг үндэслэн тухайн гишүүнийг гишүүнчлэлээс хасч болно.

- (1) Энэхүү дүрмийг зөрчсөн
  - (2) Тус байгууллагын нэр хүндэд сэв суулгасан, эсвэл зорилгод үл нийцэх үйлдэл гаргасан
2. Дээр заасны дагуу гишүүнчлэлээс хасах тухай шийдвэр гаргахаас өмнө уг

гишүүнд өөрийгөө өмгөөлөх эрх олгох ёстой.

### **Гуравдугаар бүлэг: Удирдлага**

#### **(Ангилал, орон тоо)**

Зүйл 12. Холбооны удирдлага дараах байна.

(1) Удирдах зөвлөл (цаашид УЗ гэх) -ийн бүрэлдэхүүн тав ба түүнээс доошгүй, хорь ба түүнээс ихгүй тооны гишүүнчлэлтэй байна.

(2) Хяналтын зөвлөл нэгээс гурав хүртэлх гишүүний бүрэлдэхүүнтэй байна. УЗ-ийн болоод Хяналтын зөвлөлийн гишүүнийг “Зөвшүүн” гэж нэрлэнэ.

2. УЗ-ийг бүрэлдүүлэгч гишүүдээс нэг хүн Тэргүүн, нэг хүн УЗ-ийн дарга, хоёр хүртэлх хүн УЗ-ийн дэд дарга байна.

#### **(Сонгууль)**

Зүйл 13. Зөвшүүдийг (УЗ-ийн болон Хяналтын зөвлөлийн гишүүд) Нэгдсэн хурлаас сонгоно.

2. Тэргүүн, УЗ-ийн дарга, дэд дарга нарыг УЗ-ийн хурлаас сонгоно.

3. УЗ дотор тухайн зөвшүүний өрхийн тэргүүн эсвэл гуравдугаар хамаарал доторх хамаатан нэгээс илүү байх, эсвэл уг зөвшүүнтэй ижил зэрэглэлд түүний өрхийн тэргүүн эсвэл гуравдугаар хамаарал доторх хамаатан зөвшүүдийн нийт тооны гудавны нэгээс илүү байх ёсгүй.

4. АБТЗҮАХ хуулийн 20 дугаар зүйлийн заалтуудын аль нэгэнд хамаарах хүн энэ холбооны зөвшүүн болохгүй.

5. Хяналтын зөвлөлийн гишүүн нь УЗ-ийн гишүүнээр, эсвэл Холбооны ажилтнаар хавсран ажиллахгүй.

#### **(Үүрэг хариуцлага)**

Зүйл 14. Тэргүүн нь тус холбоог төлөөлж, ерөнхийлөн удирдана.

2. УЗ-ийн дарга нь холбоог удирдлага зохион байгууллалтаар хангаж, үйл ажиллагааны ерөнхий менежментийг явуулж, Тэргүүн үүрэгт ажлаа гүйцэтгэх боломжгүй болсон тохиолдолд Тэргүүний эрх үүргийг орлон гүйцэтгэнэ..

3. УЗ-ийн дэд дарга нь УЗ-ийн даргын ажил үүрэгт тусалж, биечлэн ажиллах боломжгүй үед үүрэг хариуцлагыг орлон гүйцэтгэнэ.

4. Зөвшүүн нь УЗ-ийн хурлыг бүрэлдүүлж энэ дүрмийн дагуу болон Нэгдсэн хурал эсвэл удирдах зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн холбооны үйл ажиллагааг явуулна.

5. Хяналтын зөвлөл нь доор дурдсан үүргийг гүйцэтгэнэ.

(1) УЗ-ийн шийдвэр гүйцэтгэлийн байдалд хяналт тавих

(2) Холбооны санхүү, эд хөрөнгийн байдалд хяналт тавих

(3) Дээрх 2-р хэсэгт заасан хяналт шалгалтын дүн, холбооны үйл ажиллагаа болон хөрөнгө санхүүтэй холбоотой буруу үйл ажиллагаа, хууль ёс болон дүрэмд харш аливаа хэрэг явдлыг илрүүлсэн тохиолдолд Нэгдсэн хурал болон орон нутгийн хууль хяналтын байгууллагад мэдэгдэл гаргах.

(4) Дээрх хэсэгт заасан мэдэгдэл гаргахын тулд хэрэв шаардалагатай гэж үзвэл Нэгдсэн хурлыг зарлан хуралдуулах

(5) УЗ-ийн шийдвэр гүйцэтгэлийн байдал болон холбооны санхүү хөрөнгийн байдлын тухай УЗ-д мэдэгдэж байх

### **(Бүрэн эрхийн хугацаа)**

Зүйл 15. Зөвшүүний бүрэн эрхийн хугацаа хоёр жил байх бөгөөд дахин сонгогдох эрхтэй.

2. Нөхөн сонгуулиар сонгогдсон эсвэл зөвшүүний тоог нэмсэнтэй холбогдон явуулсан сонгуулиар сонгогдсон зөвшүүний бүрэн эрхийн хугацаа нь харгалзах өмнөх зөвшүүний, эсвэл одоо байгаа бусад зөвшүүний бүрэн эрхийн хугацааны үлдэгдэл хугацаагаар тооцно.

3. Зөвшүүн нь өөрийн хүсэлтээр больсон, эсвэл бүрэн эрхийн хугацаа нь дуусгавар болсон тохиолдолд ч дараагийн зөвшүүн томилогдох хүртэл үүрэгт ажлаа үргэлжлүүлж байх ёстой.

### **(Нөхөн сонгох)**

Зүйл 16. УЗ эсвэл хяналтын зөвлөлөөс түүний тогтоосон зөвшүүдийн тооны гуравны нэгээс илүү тооны зөвшүүд эзгүйрвэл яаралтай хойшлуулалгүй нөхөн сонгууль явуулна.

### **(Чөлөөлөх)**

Зүйл 17. Доорх тохиолдлуудын аль нэгэнд УЗ-ийн хурлын шийдвэрийг үндэслэн зөвшүүнийг үүрэгт ажлаас нь чөлөөлж болно.

(1) Эрүүл мэндийн улмаас үүрэгт ажлаа үргэлжлүүлэх боломжгүй болох

(2) Албан үүрэгтээ харш эсвэл зөвшүүний ёс зүйн хувьд тохирохгүй үйлдэл гаргах

2. Дээр дурьдсан байдлаар Зөвшүүнийг чөлөөлөх шийдвэр гаргахын өмнө тухайн зөвшүүнд тайлбар хийх боломж олгоно.

**(Урамшуулал зэрэг)**

Зүйл 18. Нийт зөвшүүдийн гуравны нэгээс бага хүрээнд зөвшүүд урамшуулал зэргийг авч болно.

2. Зөвшүүн нь үүрэгт ажлаа явуулахтай холбоотой гаргасан зардлаа нөхөн авч болно.

3. Дээрх хоёрдугаар хэсэгт хамаарах нөхцлийг Нэгдсэн хурлын шийдвэрийн хүрээнд Тэргүүн тусгайлан тогтооно.

**Дөрөвдүгээр бүлэг: Хурал**

**(Ангилал)**

Зүйл 19. Холбооны хурлыг Нэгдсэн хурал, УЗ-ийн хурал гэж 2 ангилна.

2. Нэгдсэн хурал нь ээлжит болон ээлжит бус гэж байна.

**(Нэгдсэн хурлын бүрэлдэхүүн)**

Зүйл 20. Нэгдсэн хурал нь холбооны үндсэн гишүүдийн бүрэлдэхүүнтэй явагдана.

**(Нэгдсэн хурлын үүрэг)**

Зүйл 21. Нэгдсэн хурлаар доорх асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ.

(1) Холбооны дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах

(2) Холбоог тараах болон нэгтгэх

(3) Гишүүнчлэлээс хасах

(4) Үйл ажиллагааны төлөвлөгөө, санхүүгийн төсөв тэдгээрийн өөрчлөлт

(5) Үйл ажиллагааны мэдээлэл, санхүүгийн тайлан

(6) Зөвшүүдийг сонгох ба халах

(7) Зөвшүүдийн үүрэгт ажил болон урамшуулалын хэмжээ

(8) Холбоонд элсэх хураамж болон жилийн татварын хэмжээ

(9) Зээллэг (тухайн жилийн үйл ажиллагааны орлогоос төлөх богино хугацааны зээллэг санхүүжилтыг оролцуулахгүй. 48 дугаар зүйлтэй адил) болон шинээр үйл ажиллагаа төсөвлөх ба эрх үүргийг хүчингүй болгох

(10) Холбоо татан буугдахад үлдэгдэл хөрөнгийн зохицуулалт

(11) Холбооны удирдах албан тушаалууд болон менежемент

(12) Бусад менежменттэй холбоотой чухал асуудлууд

**(Нэгдсэн хурал хуралдуулах)**

Зүйл 22. Ээлжит хурлыг жилд нэг удаа зарлан хуралдуулна.

2. Ээлжит бус хурлыг доорх тохиолдолд зарлан хуралдуулна.

(1) УЗ шаардлагатай гэж үзэж зар тараасан үед

(2) Нийт үндсэн гишүүдийн тавны нэгээс илүү тооны гишүүдийн саналаар хурлын зорилгыг дурдсан нэхэмжлэл үйлдэгдсэн үед

(3) Хяналтын зөвлөлөөс 14-р зүйлийн 5 дахь хэсгийн 4 дүгээр заалтанд үндэслэн зарлах тохиолдолд.

#### **(Нэгдсэн хурлын зар)**

Зүйл 23. Нэгдсэн хурлыг өмнөх зүйлийн 2 дахь хэсгийн 3 дахь заалтаас бусад тохиолдолд холбооны тэргүүн зарлан хуралдуулна.

2. Тэргүүн нь өмнөх зүйлийн 2 дахь хэсгийн 1 болон 2 дахь заалтын дагуух нэхэмжлэл үйлдэгдсэн тохиолдолд тухайн өдрөөс 30 хоногийн дотор ээлжит бус хурлын зарыг тараасан байх ёстой.

3. Нэгдсэн хурлыг зарлахдаа хурлын өдөр цаг, болох газар, хурлын зорилго болон хэлэлцэх асуудлуудыг дурдсан зар бичгийг хурал эхлэхээс дор хаяж 7 өдрийн өмнө биетээр эсхүл харилцаа холбооны цахим болон бусад хэлбэрээр тараасан байх ёстой.

#### **(Нэгдсэн хурлын дарга)**

Зүйл 24. Нэгдсэн хурлын даргыг тухайн хуралд оролцож байгаа үндсэн гишүүдийн дотроос сонгоно.

#### **(Нэгдсэн хурлын ирц)**

Зүйл 25. Нэгдсэн хурал нь нийт үндсэн гишүүдийн хоёрны нэгээс илүү хувийн оролцоотойгоор хүчин төгөлдөр болно.

#### **(Нэгдсэн хурлын шийдвэр)**

Зүйл 26. Нэгдсэн хурлын хэлэлцэх асуудлууд нь 23 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн дагуу урьдчилан зарлагдсан асуудлууд байна.

2. Нэгдсэн хурлын шийдвэр нь энэхүү дүрэмд тусгасан заалтаас гадна оролцогч үндсэн гишүүдийн олонхийн саналаар батлагдана. Санал тэнцсэн тохиолдолд хурал даргалагчийн санал шийдвэрлэх үүрэгтэй байна.

#### **(Нэгдсэн хурлын саналын эрх)**

Зүйл 27. Үндсэн гишүүн тус бүрийн саналын эрх тэнцүү байна.

2. Хүндэтгэх шалтгаанаар нэгдсэн хуралд оролцож чадаагүй үндсэн гишүүн нь

хурлын зард бичигдсэн хэлэлцэх асуудлуудын талаар бичгээр шуудан болон цахим хэрэгслээр саналаа ирүүлэх ба бусад үндсэн гишүүнээр өөрийгөө төлөөлүүлж санал өгч болно.

3. Дээрх хэсэгт тусгасан байдлаар саналаа өгсөн гишүүн нь 25, 26, 49-р зүйлийг харгалзан хуралд оролцсонд тооцогдоно.

4. Нэгдсэн хурлаар хэлэлцэх асуудалд ашиг сонирхолын зөрчилтэй гишүүн тухайн асуудлыг хэлэлцэн шийдвэрлэхэд оролцохгүй.

#### **(Нэгдсэн хурлын тэмдэглэл)**

Зүйл 28. Нэгдсэн хурлын хэлэлцсэн асуудлын тухай дараахь зүйлсийг тэмдэглэсэн тэмдэглэл үйлдэнэ.

(1) Хурлын огноо, газар

(2) Үндсэн гишүүдийн нийт тоо ба хуралд оролцогчдын тоо (бичгээр шуудан болон цахим хэрэгслээр саналаа оруулагч болон төлөөллөөр саналаа өгүүлж байгаа тохиолдолд тухайн тоог тэмдэглэнэ)

(3) Хэлэлцсэн асуудлын жагсаалт

(4) Санал дүгнэлтүүд, хэлэлцсэн байдал болон шийдвэрлэсэн үр дүн, санал өгсөн байдал

(5) Хурлын тэмдэглэл батламжлагч хүмүүсийг (2 хүн) хэрхэн сонгосон тухай тэмдэглэл

2. Хурлын тэмдэглэлд хурлын дарга болон хурлаар сонгогдсон хурлын тэмдэглэл батламжлагч нар гэрчилж гарын үсгээ зурсан байна.

#### **(УЗ-ийн хурлын бүрэлдэхүүн)**

Зүйл 29. УЗ-ийн хурал нь Зөвшүүдээс бүрдэнэ.

#### **(УЗ-ийн хурлын эрх, үүрэг)**

Зүйл 30. УЗ-ийн хурал нь энэхүү дүрмээс тусад нь тогтоосон асуудлууд болон дараахь асуудлыг хэлэлцэнэ.

(1) Нэгдсэн хуралд нэмж оруулах асуудлууд

(2) Нэгдсэн хурлын шийдвэрийг гүйцэтгэхтэй холбоотой асуудлууд

(3) Бусад нэгдсэн хурлаас шийдвэрлэх шаардлагагүй үйл ажиллагааг гүйцэтгэхтэй холбоотой асуудлууд

#### **(УЗ-ийн хурлыг хуралдуулах)**

Зүйл 31. УЗ-ийн хурлыг доорх тохиолдуудад зарлан хуралдуулна.

- (1) Тэргүүн эсвэл УЗ-ийн дарга шаардлагатай гэж үзсэн, хүлээн зөвшөөрсөн
  - (2) Нийт зөвшүүдийн хоёрны нэгээс олонхийн саналаар хурлын зорилго, хэлэлцэх асуудлуудыг тэмдэглэсэн нэхэмжлэл үйлдэгдсэн
2. Онц чухал бус асуудлууд болон яаралтай шийдвэрлэх шаардлагатай асуудлыг УЗ биечлэн эсхүл цахим хуралдааны хэлбэрээр хийж болно.

#### **(УЗийн хурлын зар)**

Зүйл 32. УЗ-ийн хурлыг УЗ-ийн дарга зарлан хуралдуулна.

2. УЗ-ийн дарга өмнөх зүйлийн 2 дугаарт заасан нэхэмжлэл гарсан тохиолдолд тухайн өдрөөс 14 өдрийн дотор хурлын зарыг тараана.
3. УЗ-ийн хурлыг зарлахдаа хурлын өдөр цаг, болох газар, хурлын зорилго болон хэлэлцэх асуудлуудыг дурдсан зар бичгийг хурал эхлэхээс дор хаяж 7 өдрийн өмнө бичгээр шуудан эсвэл цахим хэрэгслээр тараасан байх ёстой.

#### **(УЗ-ийн хурал даргалагч)**

Зүйл 33. УЗ-ийн хурал даргалагчийг тухай бүр зөвшүүд дундаас сонгоно.

#### **(УЗ-ийн хурлын шийдвэр)**

Зүйл 34. УЗ-ийн хурлын хэлэлцэх асуудлууд нь 32 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн дагуу урьдчилан зарлагдсан асуудлууд байна.

2. УЗ-ийн хурлын шийдвэр нь зөвшүүдийн олонхийн саналаар батлагдана. Санал тэнцсэн тохиолдолд хурал даргалагчийн санал шийдвэрлэх үүрэгтэй байна.

#### **(УЗ-ийн хурлын саналын эрх)**

Зүйл 35. Зөвшүүд тус бүр саналын тэгш эрхтэй байна.

2. Хүндэтгэх шалтгаанаар Нэгдсэн хуралд оролцож чадаагүй зөвшүүн нь хурлын зард бичигдсэн хэлэлцэх асуудлын талаарх саналаа бичгээр шуудан болон цахим хэрэгслээр ирүүлж болно.
3. Өмнөх хэсэгт тусгасан байдлаар саналаа өгсөн зөвшүүн нь 36-р зүйлийн нэгдүгээр хэсгийн заалтад харгалзаж УЗ-ийн хуралд оролцсонд тооцогдоно.
4. Удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудалд ашиг сонирхолын зөрчилтэй зөвшүүн тухайн асуудлыг хэлэлцэн шийдвэрлэхэд оролцохгүй.

#### **(УЗ-ийн хурлын тэмдэглэл)**

Зүйл 36. УЗ-ийн хуралд хэлэлцсэн асуудлуудын талаар дараахь зүйлсийг тэмдэглэсэн тэмдэглэл үйлдэнэ.

- (1) Хурлын огноо, газар
  - (2) Зөвшүүдийн нийт тоо боон хуралд оролцогчдын тоо, нэрс (бичгээр шуудан эсвэл цахим хэрэгслээр саналаа оруулагч байгаа тохиолдолд тэр тухай тэмдэглэх)
  - (3) Хэлэлцсэн асуудлуудын жагсаалт
  - (4) Санал дүгнэлтүүд хэлэлцсэн байдал болон шийдвэрлэсэн үр дүн, санал өгсөн байдал
  - (5) Хурлын тэмдэглэл батламжлагч хүмүүсийг (2 хүн) хэрхэн сонгосон тухай тэмдэглэл
2. Хурлын тэмдэглэлд хурлын дарга болон хурлаар сонгогдсон хурлын тэмдэглэл батламжлагч нар гэрчилж гарын үсгээ зурсан байна.

### **Тавдугаар бүлэг: Холбооны эд хөрөнгө**

#### **(Бүтэц)**

Зүйл 37. Холбооны эд хөрөнгө дараахаас бүрдэнэ.

- (1) Үүсгэн байгуулах анхны хөрөнгө
- (2) Гишүүнчлэлийн хураамж, татвар
- (3) Хандив, бэлэг, тусламж
- (4) Өмч хөрөнгөөс олсон орлого
- (5) Үйл ажиллагаанаас олсон орлого
- (6) Бусад орлого

#### **(Ангилал)**

Зүйл 38. Холбооны эд хөрөнгө нь ашгийн бус тодорхой заагдсан үйл ажиллагааны болон бусад үйл ажиллагааны гэсэн хоёр янзын бүртгэлтэй байна.

#### **(Зохицуулалт)**

Зүйл 39. Холбооны хөрөнгө санхүүг УЗ-ийн дарга хянан захирах бөгөөд, захиран зарцуулах арга хэлбэрийг Нэгдсэн хурлын шийдвэрийн хүрээнд УЗ тогтооно.

### **Зургадугаар бүлэг: Санхүү бүртгэл**

#### **(Санхүү бүртгэлийн үндэслэл)**

Зүйл 40. Холбооны санхүү, төсвийн тайлан тооцоог АБТЗҮАХ хуулийн 27 дугаар зүйлийн дагуу хөтлөн явуулна.

**(Санхүү бүртгэлийн ангилал)**

Зүйл 41. Холбооны санхүү бүртгэл нь ашгийн бус тодорхой заагдсан үйл ажиллагааны болон бусад үйл ажиллагааны гэсэн хоёр төрөлтэй байна

**(Санхүүгийн жил)**

Зүйл 42. Санхүүгийн жил нь 4 дүгээр сарын 1-нээс эхэлж дараа жилийн 3 дугаар сарын 31 хүртэл үргэлжилнэ.

**(Үйл ажиллагааны төлөвлөгөө, төсөв)**

Зүйл 43. Холбооны санхүүгийн жил тутмын үйл ажиллагааны төлөвлөгөө, түүнд тулгуурласан орлого зарлагын төсөв тооцоо нь УЗ-ийн даргын хариуцлага дор боловсруулагдаж Нэгдсэн хурлаар батлагдана.

**(Түр төсөв)**

Зүйл 44. Өмнөх зүйлд зааснаас үл хамааран хүндэтгэх шалтгааны улмаас төсөв бүрдээгүй тохиолдолд УЗ-ийн дарга нь УЗ-ийн шийдвэрийг үндэслэж төсөв батлагдах өдөр хүртэл өмнөх санхүүгийн жилийн төсвийг баримжаалан орлого зарлагыг захиран явуулж болно.

2. Дээрх орлого зарлага нь шинээр батлагдах төсвийн орлого зарлагад багтаж тооцогдоно.

**(Нөөц төсөв)**

Зүйл 45. Төсвийн илүүдэл болон дутуудалд зориулж, нөөц төсвийг урьдчилан тогтоож болно.

2. Нөөц төсвийн зарцуулалт УЗ-ийн шийдвэрт үндэслэнэ..

**(Төсвийн нэмэлт болон өөрчлөлт)**

Зүйл 46. Төсөв батлагдсаны дараа хүндэтгэх шалтгаан гарсан тохиолдолд Нэгдсэн хурлын шийдвэрийг үндэслэн хуучин төсөвт нэмэлт өөрчлөлт оруулж болно.

**(Үйл ажиллагааны тайлан тооцоо)**

Зүйл 47. Холбооны үйл ажиллагааны тайлан, эд хөрөнгийн бүртгэл, баланс шийт болон орлого зарлагын тооцоо зэрэг тайлан тооцоотой холбоотой баримт бичгийг тухайн санхүүгийн жил дууссаны дараа аль болох богино хугацаанд УЗ-ийн дарга удирдлага дороо боловсруулан гаргаж хяналтын зөвлөлөөр шалгуулж Нэгдсэн

хурлаар авч хэлэлцсэн байна.

2. Санхүүгийн тайлангаар илүүдэл хөрөнгө гарсан үед түүнийг дараагийн санхүүгийн жилд шилжүүлнэ.

**(Урьдчилан тогтоогүй байсан арга хэмжээ)**

Зүйл 48. Төсөвт үндэслэн тогтоосноос гадуур зээл авах зэргээр нэмэлт үүрэг хүлээх, эсвэл ямар нэг эрхээ орхих арга хэмжээ авах тохиолдолд Нэгдсэн хурлын шийдвэрийг үндэслэх ёстой.

**Долдугаар бүлэг: Дүрмийн өөрчлөлт, холбоог татан буулгах, нэгтгэх**

**(Дүрмийн нэмэлт өөрчлөлт)**

Зүйл 49. Холбооны дүрмийг өөрчлөх тохиолдолд Нэгдсэн хуралд оролцогч үндсэн гишүүдийн дөрөвний гурваас олонхийн шийдвэрийг харгалзан мөн энэхүү дүрмийн 25-р зүйлийн 3 дахь хэсэгт заасан жижиг заалтыг эс харгалзан бүртгэлийн албанаас зөвшөөрөл авсан байх ёстой.

**(Холбоог татан буулгах)**

Зүйл 50. Холбоог дараах заалтуудыг үндэслэн татан буулгана.

(1) Нэгдсэн хурлын шийдвэр

(2) Зорилго болох ашгийн бус үйл ажиллагаа хэрэгжих боломжгүй болох

(3) Үндсэн гишүүдийн тоо хүрэлцэхгүй болох

(4) Өөр байгууллагатай нэгдэх

(5) Дампуурлын өргөдөл гаргах шийдвэр гарсан

(6) Бүртгэлийн албаны бүртгэлээс хасагдах

2. Өмнөх зүйлийн 1 дүгээр хэсгийн заалтуудын дагуу энэхүү холбоог татан буулгах тохиолдолд нийт үндсэн гишүүдийн тооны дөрөвний гурваас олонхын саналыг харгалзан үзэх ёстой.

3. Энэ зүйлийн 1 дүгээр хэсгийн (2) заалтын дагуу холбоог татан буулгах тохиолдолд бүртгэлийн албаны зөвшөөрлийг харгалзан үзнэ.

**(Үлдэгдэл эд хөрөнгийг буцаах)**

Зүйл 51. Холбоог татан буулгасан тохиолдолд (өөр байгууллагатай нэгдэх болон дампуурлын өргөдөл гаргах шийдвэр гаргаж татан буулгасныг эс тооцон) үлдэгдэл хөрөнгийг дүрмийн 11 дүгээр зүйл 3 дугаар хэсэгт заагдсан этгээдүүдээс Нэгдсэн хурлаас шийдвэрлэсэн этгээдэд шилжүүлнэ.

**(Холбоог нэгтгэх)**

Зүйл 52. Энэхүү холбоог бусад байгууллагатай нэгтгэх тохиолдолд Нэгдсэн хурлаар нийт үндсэн гишүүдийн дөрөвний гурваас олонхийн шийдвэрийг харгалзах бөгөөд мөн бүртгэлийн албаны зөвшөөрлийг авсан байх ёстой.

**Наймдугаар бүлэг: Албан мэдээллийн аргууд**

**(Албан мэдээллийн аргууд)**

Зүйл 53. Холбогдох хууль дүрэмд заагдсаны дагуух албан үүрэгт мэдээллийг вэбсайт зэрэг холбооны албан ёсны мэдээллийн хэрэгсэл болон Төрийн захиргааны мэдээллээр (“канпоо”) гаргаж олон нийтэд хүргэнэ.

**Есдүгээр бүлэг: Ажлын алба**

**(Ажлын алба байгуулах)**

Зүйл 54. Холбоо нь албан хэргийн гүйцэтгэл, тасралтгүй ажиллагааг хангах ажлын албатай байна.

2. Ажлын алба нь албаны дарга болон албан хаагчтай байна.

**(Албан хаагчийн томилгоо)**

Зүйл 55. Ажлын албаны дарга болон албан хаагчийг УЗ-ийн дарга томилно.

**(Удирдлага, зохион байгуулалт)**

Зүйл 56. Ажлын албаны зохион байгуулалт, удирдлагатай холбоотой асуудлыг Удирдах зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн УЗ-ийн дарга жич тогтооно.

**Аравдугаар бүлэг: Бусад**

**(Нарийвчилсан зохицуулалт)**

Зүйл 57. Энэхүү дүрмийг хүчин төгөлдөржүүлэхтэй холбоотой бусад зохицуулалтыг УЗ-ийн хурлын шийдвэрийг үндэслэн УЗ-ийн дарга тогтооно.

**(Хүчин төгөлдөржилт)**

1. Энэхүү дүрэм нь Холбоо байгуулагдсан өдрөөс эхэлж хүчин төгөлдөр болно.
2. Холбоог үүсгэн байгуулагч анхны зөвшүүдийг дор дурдав.

Тэргүүн	У.Өлзийням
УЗ-ийн дарга	М.Тулгат
УЗ-ийн дэд дарга	Д.Маралгоо
УЗ-ийн дэд дарга	Д.Хүдэр
УЗ-ийн гишүүн	С.Лхамчимэг
УЗ-ийн гишүүн	Г.Суурь
УЗ-ийн гишүүн	Ц.Энхзаяа
УЗ-ийн гишүүн	Ч.Баасандаш
УЗ-ийн гишүүн	А.Отгонбаяр
УЗ-ийн гишүүн	Г.Лхагвадорж
УЗ-ийн гишүүн	Б.Мөнх-Уянга
УЗ-ийн гишүүн	Б.Эрдэнэбулган
УЗ-ийн гишүүн	Б.Баянмөнх
УЗ-ийн гишүүн	Д.Тэгшжаргал
УЗ-ийн гишүүн	С.Ган-Од
Хяналтын зөвшүүн	Ц.Нандинбаатар

3. Холбоог байгуулах анхны зөвшүүдийн сонгуульт хугацааг 15-р зүйлийн 1 дэх хэсэгт зааснаас эс хамааруулан холбоог байгуулсан өдрөөс эхлэн 2010 оны 6 сарын 30 өдөр хүртэл гэж тогтоно.

4. Холбоог байгуулах эхний санхүүгийн жил нь 42 дугаар зүйлээс үл хамаарч холбоог албан ёсоор байгуулсан өдрөөс эхлэн тухайн санхүүгийн жил дуусах огноо буюу 2010 оны 3 сарын 31 хүртэл үргэлжилнэ.

5. Холбоог байгуулах эхний үйл ажиллагааны төлөвлөгөө болон төсвийг 43 дугаар зүйлээс үл хамаарч холбоог үүсгэн байгуулах хурлаар тогтооно.

6. Холбоог байгуулах анхны жилийн гишүүнчлэлийн хураамж болон татварыг 8 дугаар зүйлээс үл хамаарч доорх байдлаар тогтооно. Харин үүсгэн байгуулагч зөвшүүдийн тухайд жилийн татварыг хагас дүнгээр тогтооно.

(1) Бүртгэлийн хураамж:

Үндсэн гишүүн (хувь хүн / байгууллага) 0 иен / 5000 иен

Энгийн гишүүн (хувь хүн / байгууллага) 0 иен / 5000 иен

(3) Жилийн татвар

Үндсэн гишүүн (хувь хүн / байгууллага) 4000 иен / 10000 иен

Энгийн гишүүн (хувь хүн / байгууллага) 2000 иен / 5000 иен

БАТЛАВ.

ХУРАЛ ДАРГАЛАГЧ М.ТУЛГАТ  
ХУРЛЫН ТӨЛӨӨЛӨГЧИД

2009/01/31 ТОКИО ХОТ